

**Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн
ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ**

**Өмнөговь аймаг
Ханбогд сум**

2017 оны 03-р сарын 22

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн (ГТЗ)¹ хурал 2017 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Хуралд ГТЗ-ийн гишүүд, Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газрын (ЭЗНХЗОГ)² чиглүүлэгч нар болон Олон улсын Санхүүгийн Корпорацийн (ОУСК) төлөөллүүд ажиглагчаар оролцсон болно.

Энэ хурлын үр дүнд ОТ төслийн нөлөөнд өртсөн орон нутгийн нүүдэлчин малчин иргэд “Говийн газар шороо” ТББ-д нэгдэн зохион байгуулалтанд орж Улаанбаатар хотод байршилтай “ОюуТолгойн Хяналт” ТББ-ийн дэмжлэгтэйгээр 2012-2013 онуудад ЭЗНХЗОГ –т хандан гаргасан Ундайн голын голидрол өөрчилсөнтэй холбоотой гомдол болон 2004, 2011 оны нөхөн олговрын гэрээтэй холбоотой гомдлыг шийдвэрлэх асуудлаар Талууд тохиролцоонд хүрлээ. ГТЗ эдгээр гомдлыг шийдвэрлэхийн тулд 2014-2016 онуудад гурван төрлийн үнэлгээ судалгааны ажлыг хөндлөнгийн бие даасан судлаачдын багаар хийлгэсэн юм. Үүнд Олон талт мэргэжлийн шинжээчдийн багийн хэрэгжүүлсэн Ханбогд сумын малчдын ахуй амьжиргаа, нийгэм соёлын байдалд гарсан сүүлийн арав гаруй жилийн өөрчлөлт, үүнд Оюу толгой компанийн үйл ажиллагааны нөлөөлөл, нөхөн олговрын хөтөлбөр зохистой байсан эсэх талаар хараат бус үнэлгээ болон Хөндлөнгийн шинжээчдийн багийн хэрэгжүүлсэн Ундай голын гольдрол өөрчлөлтийн улмаас үүссэн хам нөлөөллийн 1, 2-р шатны судалгаа багтаж байгаа бөгөөд эдгээр судалгааны зөвлөмжинд үндэслэн гомдлыг шийдвэрлэхэд чиглэсэн ажлын талаар Талууд тохиролцоонд хүрээд байна. Малчдын гаргасан хоёр гомдлыг шийдвэрлэхийн тулд хийхээр тохирсон ажлуудаас нөхөн олговортой холбоотой хэсгийг гомдол тус бүрээр хүргэж байна. Үүнд:

- 1. 2004, 2011 оны нөхөн олговрын гэрээтэй холбоотой гомдлыг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлэхээр тохирсон үйл ажиллагаа:**
 - a. Айванхо Майнс Монголиа Инк (АММИ)-н 2004 оны нүүлгэн шилжүүлэлтэнд хэрэглэсэн арга барил нь ялангуяа харилцаа холбооны тухайд асуудалтай байсныг ОТ малчдын өмнө хүлээн зөвшөөрч 2004 онд нүүлгэн шилжүүлсэн өрхүүдийн асуудлыг шийдэхийн тулд ГТЗ-тэй хамтран ажиллах;
 - b. ГТЗ нь Эрх Зүйн Нийцэл, Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газрын (ЭЗНХЗОГ) адил хөндлөнгийн бие даасан нарийн бичгийн даргын тусламжтайгаар дараах ангиллын малчид 2004, 2011 оны хөтөлбөрийн дагуу нөхөн олговор авах эрхтэй эсэхийг шийдвэрлэх “Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороо”-ны үүрэг гүйцэтгэж ажиллах;
 - c. Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хорооны үйл ажиллагааны журмыг хамтран боловсруулж ашиглах;

¹ Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газраас (ЭЗНХЗОГ) чиглүүлж байна.

² Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗНХЗОГ) бол Дэлхийн Банкны Группын Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) болон Олон Талын Хөрөнгө Оруулалтын Баталгааны Байгууллагатай (ОТХОББ) холбоотой асуудлаар хөндлөнгийн хараат бус хариуцлагын механизмын үйлчилгээ үзүүлдэг хараат бус, бие даасан байгууллага болно.

- d. **Дараах шалгуур хангасан малчид 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн гэрээнд хөөн хэлэлцүүлж орох хүсэлтээ нөхөн олговрын нэхэмжлэлийн хороонд тавих боломж олгох:**
- Заасан бүсэд өвөлжөөний байгууламжтай, нотлох баримттай (байгууламж, гэрчилгээ, үл мөр гэх мэт)
 - Нүүлгэн шилжүүлэлтийн гэрээгүй, заасан бүсэд хаваржааны байгууламж, үл мөр, нотлох баримттай
 - Нэг өвөлжөө хуваан эзэмшиж байсан, ямарч нөхөн олговор аваагүй, тухайн үед малчин өрхийн бүртгэлтэй байсан, нутгийн иргэд нотлох өрх
- e. **2004 онд нүүлгэн шилжүүлэлтэнд хамрагдсан 10 өрхийн хувьд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх:**
- 2004 оны нүүлгэн шилжүүлсэн өрхөөс ажлын байргүй байгаа 2 өрхийг Амьжиргааг дэмжих тэтгэлэгтэй сургалтанд нэг жилийн хугацаанд хамруулах;
 - 2004 онд нүүлгэн шилжүүлсэн 10 өрхийг тогтвортой амьжиргааны хөтөлбөрт хамруулах (Энэ хөтөлбөрт хашаа хороог нь хангалттай түвшинд хүргэхийн тулд ОТ-оос засаж сэлбэх эсвэл сольж барих асуудлыг тусгах);
- f. **2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн заасан бүсэд өвөлжөө, хаваржаатай байсан, 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртөж нөхөн олговор авах шалгуурыг шинээр хангасан малчдад дараах нөхөн олговрыг олгох (2004 онд олгож байсан нөхөн олговрын хэмжээтэй дүйцэхүйц эсвэл тухайн багцаас бууруулахгүй нөхөн олговор олгох гол зарчмыг баримтлах):**
- Хороо бууц
 - Худаг
 - Зуны сууц
 - 32 толгой мал
 - Байнгын ажлын байртай дүйцэхүйц хэмжээний орлогын эх үүсвэр бий болгоход туслах
 - Сургалтанд хамруулах
 - Боловсрол эзэмшихэд үзүүлэх тусламж (2 оюутны сургалтын зардал, орон байр сууцны төлбөр, нэг жилд хоёр удаа ирж очих замын зардал, оюутанд олгох хангамж)
 - Тогтвортой амьжиргааны хөтөлбөрт хамруулах
- g. **2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн заасан бүсэд өвөлжөө хуваан эзэмшиж байсан, 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд өртөж нөхөн олговор авах шалгуурыг шинээр хангасан малчдад дараах нөхөн олговрыг олгох (2004 онд олгож байсан хам нөхөн олговрын хэмжээтэй дүйцэхүйц эсвэл тухайн багцаас бууруулахгүй нөхөн олговор олгох гол зарчмыг баримтлах):**
- 32 толгой мал
 - Байнгын ажлын байртай дүйцэхүйц хэмжээний орлогын эх үүсвэр бий болгоход туслах
 - Сургалтанд хамруулах
 - Боловсрол эзэмшихэд үзүүлэх тусламж (2 оюутны сургалтын зардал, орон байр сууцны төлбөр, нэг жилд хоёр удаа ирж очих замын зардал, оюутанд олгох хангамж)
 - Тогтвортой амьжиргааны хөтөлбөрт хамруулах
- h. **Дараах шалгуур хангасан малчид 2011 оны нөхөн олговрын хөтөлбөрт хөөн хэлэлцүүлж орох хүсэлтээ нөхөн олговрын нэхэмжлэлийн хороонд тавих боломж олгох:**
- Нөхөн олговрын гэрээгүй, заасан бүсэд хаваржааны байгууламж эзэмшдэг гэрчилгээтэй, засаг даргын захирамжийн хамт, үл мөр, нотлох баримттай
 - Нөхөн олговрын заасан бүсэд өвөлжөөний байгууламжтай, гэрчилгээгүй боловч нотлох баримттай (байгууламж, үл мөр гэх мэт)
 - Нөхөн олговрын гэрээгүй, нэг өвөлжөө хуваан эзэмшиж байсан, ямарч нөхөн олговор

аваагүй, тухайн үед малчин өрхийн бүртгэлтэй байсан, нутгийн иргэд нотлох өрх

- i. **2011 онд нөхөн олговор авсан 89 өрхийн хувьд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх:**
- 2011 оны нөхөн олговрын гэрээний хэрэгжилт, үр дүнд хөндлөнгийн аудит хийлгэх;
 - Нөхөн олговроо гүйцэд аваагүй эсвэл ямар нэгэн гомдол санал гаргасан өрхүүдийн асуудлыг Нэхэмжлэлийн хороогоор шийдвэрлэх;
 - Аудитын дүгнэлтийг харгалзаж гэрээг дуусгавар болгох эсвэл цаашид аливаа арга хэмжээ авах эсэх асуудлыг Нөхөн Олговрын ажлын хэсэг/Гурван Талт зөвлөл шийдвэрлэх;
 - Тогтвортой амьжиргааны хөтөлбөрт хамруулах
- j. **2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн заасан бүсэд өвөлжөө, хаваржаатай байсан, 2011 оны нөлөөллийн нөхөн олговор авах шалгуурыг шинээр хангасан малчдад дараах нөхөн олговрыг олгох (2011 онд олгож байсан нөхөн олговрын хэмжээтэй дүйцэхүйц эсвэл тухайн багцаас бууруулахгүй нөхөн олговор олгох гол зарчмыг баримтлах):**
- Тухайн үед ямар ангиллаар нөхөн олговрын гэрээ байгуулж байсан тухайн багцаас бууруулахгүй, дүйцэхүйц нөхөн олговор олгох
- k. **2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн заасан бүсэд өвөлжөө хуваан эзэмшиж байсан, 2011 оны нөлөөллийн нөхөн олговор авах шалгуурыг шинээр хангасан малчдад дараах нөхөн олговрыг олгох (2011 онд олгож байсан хам нөхөн олговрын хэмжээтэй дүйцэхүйц эсвэл тухайн багцаас бууруулахгүй нөхөн олговор олгох гол зарчмыг баримтлах):**
- Тухайн үед ямар ангиллаар хам өрхүүдэд олгож байсан нөхөн олговрын гэрээ байгуулж байсан тухайн багцаас бууруулахгүй, дүйцэхүйц нөхөн олговор олгох (Жишээлбэл боловсролын дэмжлэг (оюутны, сурагчийн), амьжиргааг дэмжих хөтөлбөрт хамруулах, сургалтанд хамруулах, бэлчээрийн менежментийн хөтөлбөрт хамруулах гэх мэт)
- l. 2004 ба 2011 оны нөхөн олговрын гэрээний нууцлалыг хадгалах тухай зүйл заалтыг цуцалж ингэснээр нөхөн олговор авсан иргэд нөхөн олговрын талаарх мэдээллээ бусдад ил болгохыг хүсвэл энэ боломжийг нээлттэй болгох;
- m. **2004, 2011 оны нөлөөллийн бүсийн дөнгөж гадна үлдсэн өрхүүд, шүүд бус нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдэд дараах нөхөн олговрыг олгож зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;**
- Нийтийн нөхөн олговрын хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаанд давуу боломж олгох
 - Малчдын оюутан хүүхдүүдийн сургалтын тэтгэлэг олгох – (тохиролцоонд хүрсэн өдрийн байдлаар оюутан байгаа хүүхдүүдийг нь төгстөл олгох) – Ингэхдээ голч оноо нь 2.7-оос дээш, Сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр суралцаж буй оюутнуудад олгох
 - Тогтвортой амьжиргааны хөтөлбөрт хамруулах
 - Мониторингийн цалинтай ажилд хамруулах (бүлгийн зохион байгуулалтанд оруулж, гэрээ байгуулж ажиллахаар зохион байгуулах, мониторингийн ажлыг дахин зохион байгуулж сайжруулах ажилтай уялдуулах)
- n. Ханбогд сумын бүх малчин өрхүүдэд нийтийн нөхөн олговор байдлаар урт болон богино хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тохиров:
- Урт хугацаанд: ХБ сумын 2024 он хүртэлх МААХХ-ийн хүрээнд Өмнөговь, Ханбогд ба ОТ-н хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжүүлэхээр тохирсон урт хугацаанд хэрэгжүүлэх төслүүд
 - Богино хугацаанд:

- **Амьжиргааг дэмжих төсөл хэрэгжүүлэх**
 - i. Амьдрах ухааны сургалт явуулах
 - ii. Хиймэл нуур цөөрөм, хур борооны ус цуглуулах хөв байгуулах;
 - iii. Худаг засварын бригад ажиллуулах;
 - iv. “Малчны зах” байгуулж ажиллуулах;
 - v. Гүн өрмийн худгийг сэргээгдэх эрчим хүчинд холбоход дэмжлэг үзүүлэх;
 - vi. Залуу малчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх, “Залуу малчин” төсөл хэрэгжүүлэх (ХБ сумын 2024 он хүртэлх МААХХ-т тусгагдсан)
 - ЖДБ-ыг чадавхжуулах сургалт явуулах, жижиг зээл авах боломж олгох (ХААН БАНК-аар дамжуулан 30 сая хүртэлх зээлийг шаардлага хангасан төсөлд олгохоор тохирсон)
 - i. Шууд ханган нийлүүлэлт хийх цэгүүдийг байгуулж, үйлдвэрлэгчидтэй шууд холбох;
 - ii. Бизнес эрхлэх дэмжлэг үзүүлэх;
 - Малчдын оюутан хүүхдүүдийн сургалтын тэтгэлэг олгох – (тохиролцоонд хүрсэн өдрийн байдлаар оюутан байгаа хүүхдүүдийг нь төгстөл олгох) – Ингэхдээ голч оноо нь 2.7-оос дээш, Сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр суралцаж буй оюутнуудад олгох
 - **Дэд бүтцийн талаар гаргасан саналыг хэрэгжүүлэх**
 - i. Ханбогд сумын сайжруулсан замыг хатуу хүчилттай болгох;
 - ii. Ханбогд суманд дэд бүтэц бий болгох (цэвэр бохир усны шугам бий болгох)
 - Мониторингийн цалинтай ажилд хамруулах (бүлгийн зохион байгуулалтанд оруулж, гэрээ байгуулж ажиллахаар зохион байгуулах, мониторингийн ажлыг дахин зохион байгуулж сайжруулах ажилтай уялдуулах)
 - Эрүүл мэндийн үйлчилгээг малчдад үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх (Жишээ нь, малчдад зориулсан явуулын үзлэг, оношлогоо хийх, эргэлтийн эмийн сан зохион байгуулах гэх мэт)
- o. Ханбогд Сумын захиргаа харилцаа холбооны сүлжээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд Юнителийн сүлжээний антенныг Гавилууд багт байрлуулах ажлыг хэрэгжүүлэх
- 2. 2013 оны 2 дугаар сард нутгийн долоон (7) малчид Оюу Толгой компанийн Ундайн голын гольдролыг өөрчлөх төслийн нөлөөллийн асуудлаар гаргасан гомдлын нөхөн олговортой холбоотой асуудлаар Талууд дараах тохиролцоонд хүрээд байна. Үүнд:**
- 1. Ундай голын сав газарт нутагладаг малчин өрхүүдийн амьжиргааг дэмжих дараах ажлуудыг хэрэгжүүлэх (Гол шалгуур: 2007 оноос хойш 2012 оны 12-р сарын 29-ны хооронд сумын бүртгэлд малчин өрхөөр бүртгэлтэй, Ундай голын ай сав газарт өвөлжөө хаваржаа эзэмшин амьдарч байгаа өрхүүд):**
- Сумын Ахмадын Хороотой хамтран Ундайн гол дагуух өрхүүдийн ахмад настангуудыг хамруулан уламжлалт мал аж ахуйн өв, мэдлэгээ залуучуудад таниулан түгээх, зөвлөх, өвлүүлэх зорилготой төсөл хэрэгжүүлж, урамшуулал олгох;
 - Ажлын байранд мэргэжлийн үр чадварыг дадлагажуулан сургах сургалтанд давуу байдлаар хамруулах асуудлыг судлаад дахин хэлэлцэх;
 - Малчдын оюутан хүүхдүүдийн сургалтын тэтгэлэг олгох – (тохиролцоонд хүрсэн өдрийн байдлаар оюутан байгаа хүүхдүүдийг нь төгстөл олгох) – Ингэхдээ голч оноо нь 2.7-оос дээш, Сум орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр суралцаж буй оюутнуудад олгох;
 - Тогтвортой амжиргааны хөтөлбөрт хамруулах;
 - Мониторингийн цалинтай ажилд хамруулах (бүлгийн зохион байгуулалтанд оруулж, гэрээ байгуулж ажиллахаар зохион байгуулах, мониторингийн ажлыг дахин зохион байгуулж сайжруулах ажилтай уялдуулах)

Талууд дээр дурдсан тохиролцооноос гадна бэлчээр, устай холбоотой, мониторинг хийх, хамтран ажиллахтай холбоотой өөр олон тохиролцоонд хүрсэн бөгөөд Талуудын тохирсон ажлыг хэрэгжүүлэх хугацаа бүхий дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөө гаргаж, хамтран ажиллахаар болоод байна. Гомдлыг барагдуулахын тулд хийхээр тохирсон ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтыг ОТ компани хариуцахаар талууд тохиров.

Ингэснээр ЭЗНХЗОГ-ийн гомдол барагдуулах механизмийн дагуу энэ 2 гомдлыг хэлцлийн үе шатнаас “хэрэгжилт мониторингийн” үе шат руу оруулахаар тохирлоо. Зөвлөлийн дараагийн хурлаар Талууд энэхүү тохиролцоог баталгаажуулсан санамж бичиг байгуулж гарын үсэг зурах юм.

Хийхээр тохирсон ажлын хүрээнд Ханбогд сумын нийт малчдад үр өгөөжөө өгөх Тогтвортой амьжиргааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд энэ хөтөлбөрийг Зөвлөлийн талууд хамтран боловсруулахад Ханбогд сумын засаг захиргаа тэргүүлж оролцохоор талууд тохирлоо.

Зөвлөлийн дараагийн хурлыг 2017 оны 4 дүгээр сарын 24-нд хийхээр товлов.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл